

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын ГЭРЧИЛГЭЭ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	5
2.9. Зорилтот түвшний биелэлт	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2.Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	12
4.3.Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
5. Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН
ХАДГАЛАМЖИЙН ТӨВ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ж.БАЙГАЛМАА ТАНАА

2020.03.13 № 06/789
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалтад заасны дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



9006109
9019120396

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн гүйцэтгэх захирал Ж.Байгалмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн Шилэн дансны хуулийг бүрэн хэрэгжүүлэх, авлагыг баталгаажуулах, дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Юнистар аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 01/696 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК –ийн эрхэм зорилго нь үнэт цаасны хадгаламж, өмчлөх эрхийн бүртгэлийн аюулгүй байдлыг ханган, үйл ажиллагаагаа шударга, шуурхай, ил тод явуулан үнэт цаасны зах зээлийг төлөвшүүлэн хөгжүүлэхэд оршино.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа
- үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг Хувь хүний орлогын албан татварын тухай хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулиудад өөрчлөлт орсон.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн дотооддоо боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн “СоларСис” програм хангамж ашиглаж байна.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн тайлангийн нийт орлогыг сонгож эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 3,390.7 сая төгрөгөөс тооцон 33.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2019 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,182.0 сая төгрөгөөр буюу 12.8 хувиар буурсан байна. Оны эхний үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, бараа материал дансны үлдэгдэл өсөж, бусад санхүүгийн хөрөнгө, урьдчилж гарсан зардал/тооцоо, үндсэн хөрөнгө, урт хугацаат хөрөнгө оруулалт болон биет бус хөрөнгө дансны үлдэгдэл буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,146.6	16,462.7	14,316.1
Авлага	1,041.1	194.3	(846.8)
Бусад санхүүгийн хөрөнгө	5,900.0	-	(5,900.0)
Бараа материал	14,835.0	16,756.5	1.9
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	26,858.74	24,129.56	(2,729.19)
Үндсэн хөрөнгө	1,541.9	1,499.9	(42.0)
Биет бус хөрөнгө	30.8	28.1	(2.7)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	6,257.4	912.8	(5,344.6)
Хойшлогдсон татварын хөрөнгө	6.5	9.4	2.8
Нийт хөрөнгө	16,966.2	19,148.2	2,182.0
Богино хугацаат өр төлбөрийн дүн	10,787.5	11,676.6	889.1
Урт хугацаат өр төлбөрийн дүн	100.0	100.0	-
Эздийн өмч: - төрийн	3,000.0	3,000.0	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	98.7	98.7	-
Эздийн өмчийн бусад хэсэг	26.6	26.6	-
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	2,953.3	4,246.2	1,292.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	16,966.2	19,148.2	2,182.0

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 14,316.1 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант онд 5,900.0 сая төгрөгийн хадгаламж, 846.8 сая төгрөгийн авлага, 5,344.6 сая төгрөгийн бонд төлөгдсөн болон компани 2019 онд 1,666.5 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласантай холбоотой.

Авлага дансны үлдэгдэл 846.8 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны дансны болон хүүгийн авлага төлөгдсөнтэй холбоотой байна. Авлага дансны үлдэгдэлд 2003 онд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК байгуулагдахад Хөрөнгийн биржээс шилжиж ирсэн, дампуурсан банкуудад байршиж байсан харилцагчдын мөнгөний үлдэгдэл 130.7 сая төгрөгийн Сангийн яамнаас авах авлага, 1995-2000 онд үүссэн, шүүхээс 2014 онд хэрэгсэхгүй болгосон брокер дилерийн компаниудаас авах 8.0 сая төгрөгийн авлага нийт 138.8 сая төгрөгийн авлага шийдвэрлэгдээгүй удсан байна. Мөн 2018 оны худалдан авах ажиллагаатай холбоотой үүссэн 25.0 сая төгрөгийн авлага маргаантай байна. Эдгээр авлагуудаас Сангийн яамнаас авах 130.8 сая төгрөгийг төрийн өмчийн ногдол ашгаар хаах хүсэлтийг 2018 онд Сангийн яаманд тавьсан, шүүхээр хэрэгсэхгүй болгосон 8.0 сая төгрөгийн авлагыг найдваргүй авлагаар бүртгэж эрсдэлийн сангаас хаахаар 2020 оны санхүүгийн төлөвлөгөөндөө тусгасан байна. Харин тооцоо нийлж баталгаажуулаагүй, маргаантай байгаа 25.0 сая төгрөгийн асуудлыг алдаа зөрчилд тооцон зөвлөмж өгсөн ба дээрхи авлагуудын шийдвэрлэлтийг дараагийн аудитаар анхаарч үзэх анхаарал татахуйц асуудалд оруулсан болно.

Бусад санхүүгийн хөрөнгө дансанд 5,900.0 сая төгрөгийн хадгаламж бүртгэлтэй байсан ба тайлант онд гэрээний хугацаа дуусч мөнгөө татсанаар үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1.9 сая төгрөгөөр өссөн нь хангамжийн материал өсөлттэй холбоотой байна.

Урьдчилж төлсөн зардал/тооцоо/ дансны үлдэгдэл 2.7 сая төгрөгөөр буурсан боловч тогтвортой үлдэгдэлтэй байгаа нь компани Олон улсын үнэт цаасны байгууллагад төлдөг гишүүнчлэлийн хураамжаа жилд 2 удаа шилжүүлж тайлангийн хугацаанд нь зардлаар бүртгэдэгтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 41.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд 67.9 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, 109.8 сая төгрөгийн элэгдэл байгуулж, зардлаар бүртгэснээс шалтгаалжээ.

Хөрөнгө худалдан авах ажиллагаа нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-ийн хурлын 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу хийгдсэн байна. Мөн компанийн ТУЗ-ийн 2019 оны 19 дүгээр тогтоолыг үндэслэн элэгдлээрээ өртгөө нөхсөн 9.5 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Тайлант онд 2.6 сая төгрөгийн элэгдэл байгуулж бүртгэснээр биет бус хөрөнгө дансны үлдэгдэл буурсан байна.

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл 5,344.6 сая төгрөгөөр буурсан нь 6 төрлийн бондоос дөрвийнх нь хугацаа дуусч мөнгө нь төлөгдсөнтэй холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 889.1 сая төгрөгөөр өссөн нь үнэт цаас эзэмшигчдийн дансны үлдэгдэл 949.4 сая төгрөгөөр өссөнөөс голлон шалтгаалсан байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 19,148.2 сая төгрөг болж 1,292.9 сая төгрөгөөр өссөнд тайланд онд ашигтай ажилласан нь нөлөөлжээ.

2.9. ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ БИЕЛЭЛТ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасны дагуу хөрөнгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, удирдлага нь энэ хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, үүргийг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2019 оны зорилтот түвшинг Сангийн сайдын 2019 оны 147 дугаар тушаалаар баталсан байна. Уг зорилтот түвшингээр тус компани нь 3,566.6 сая төгрөгийн нийт орлоготой, 1,611.5 сая төгрөгийн зардалтай ажиллах, үүнээс удирдлагын зардал 103.0 сая төгрөг байхаар төлөвлөсөн байна. Мөн татварын өмнөх ашиг 1,955.0 сая төгрөг, цэвэр ашиг 1,855.0 сая төгрөг, борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал 0,45 төгрөг байх зорилт тавьсан байна.

Компанийн санхүүгийн гүйцэтгэлээр 3,375.2 сая төгрөгийн нийт орлого олж орлогын төлөвлөгөө 94.6 хувиар биелсэн бол, нийт зардал 1,539.2 сая төгрөг болж төлөвлөснөөс 72.3 сая төгрөгөөр хэмнэгджээ. Цэвэр ашиг 1,855.0 сая төгрөгөөр төлөвлөгдсөн бол гүйцэтгэлээр 1,666.5 сая төгрөг болж 89.8 хувийн биелэлттэй байна. Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардлыг 0,45 төгрөгт багтаахаар зорилт тавьсан бол гүйцэтгэлээр 0,46 төгрөгийн зардал гаргасан байна. Удирдлагын зардал 99.5 хувийн биелэлттэй байна.

Нийт орлого болон цэвэр ашиг зорилтот түвшинд хүрээгүй нь үнэт цаасны хадгаламжийн үйлчилгээний орлого 109.0 сая төгрөгөөр, бусад орлого 80.2 сая төгрөгөөр, үйл ажиллагааны бус орлого 89.8 сая төгрөгөөр тус тус тасарсантай холбоотой байна. Үйл ажиллагааны бус орлого буурахад хадгаламж буурч хүүгийн орлого багассан нь нөлөөлсөн байна.

Нийт авлага 19.3 сая төгрөгөөр, нийт өр 26.4 сая төгрөгөөр тус тус төлөвлөгдсөн хэмжээнээс хэтэрсэн байна.

2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд 13 эрсдэл тодорхойлж, гүйцэтгэлийн үе шатанд 1 эрсдэлтэй асуудал нэмж тодорхойлон нийт 14 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1, авлагатай холбоотой 24.9 сая төгрөгийн 1 алдаа зөрчил илэрсэнд алдаа зөрчлийг арилгах, хууль хэрэгжүүлж ажиллах 2 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК байгуулагдахад Хөрөнгийн биржээс шилжиж ирсэн, дампуурсан банкуудад байршиж байсан харилцагчдын мөнгөний үлдэгдэл 130.6 сая төгрөгийн авлага, 1995-2000 онд үүссэн, 2014 онд шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгосон 8.0 сая төгрөгийн авлага, худалдан авах ажиллагаатай холбоотой үүссэн, маргаантай 25.0 сая төгрөгийн авлагын шийдвэрлэлтийг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК нь Шилэн дансны тухай хуулийн 3.1.1-д хамаарах байтал 3.1.3 дахь заалтад хамааруулан эрх олгосноос зөвхөн хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний мэдээлэл оруулсан байна. Нийт 50 мэдээлэл оруулснаас 30 мэдээллийг хугацаанд нь, 20 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт, албан шаардлага өгөөгүй бөгөөд 3 зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн, зөвлөмжийн биелэлт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-ийн 2019 оны санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, НББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан асуудлууд нь санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

2018 онд 13 ширхэг компьютер худалдан авахаар сонгон шалгаруулалт явуулж, бэлтгэн нийлүүлэгчид 25,3 сая төгрөг шилжүүлсэн байна. Гэвч нийлүүлсэн компьютерүүд техникийн шаардлага хангаагүй тул хохирлоо нэхэмжилсэн боловч шүүх нэхэмжлэлийн шаардлага хангаагүй гэх үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байна. Энэ тооцооноос 24,995.8 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл бүртгэлтэй, маргаантай хэвээр байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "...үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах.." гэж заасанд нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Эрсдэл:

Байгууллагын авлага найдваргүй болох, компанид хохирол учрах.

1.3 Өгсөн зөвлөмж:

Маргаантай байгаа 24,995.8 мянган төгрөгийн авлагыг хуулийн дагуу нэхэмжилж буруутай этгээдээр төлүүлэх, барагдуулах арга хэмжээ авах.

1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хуулийн шаардлага хангуулан нэхэмжлэлээ шүүхэд дахин гаргахаар ажиллаж байна. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК нь Шилэн дансны тухай хуулийн 3.1.1-д хамаарах байтал 3.1.3 дахь заалтад хамааруулан эрх олгосноос зөвхөн худалдан авах ажиллагаа, том дүнтэй гэрээ хэлцлийн мэдээлэл оруулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 6 дугаар зүйлийг тус тус зөрчсөн байна.

2.2 Эрсдэл:

Хууль хэрэгжихгүй байх, төрийн өмчийн ил тод байдал хангагдахгүй байх, хяналт сулрах.

2.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох байгууллагад хандаж шилэн дансны эрхээ нээлгэх, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг уг хуульд заасан шаардлагын дагуу хугацаанд нь бүрэн мэдээлж байх, цаашид хууль зөрчихгүй ажиллах.

2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Сангийн яамнаас эрх нь нээгдсэн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг жилээр, концессийн мэдээлэл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, Бондын өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр, их хэмжээнд тооцогдохуйц хэлцэл,хөрөнгийн болон тендерийн мэдээллийг тухай бүрт мэдээлж ажилласан. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
Б	1	2
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,146,641,358.89	16,462,726,509.49
Дансны авлага	63,417,831.44	30,367,437.20
Бусад авлага	977,723,363.00	163,909,953.94
Бусад санхүүгийн хөрөнгө	5,900,000,000.00	-
Бараа материал	14,835,499.60	16,756,517.60
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	26,858,741.22	24,129,555.50
Эргэлтийн хөрөнгийн дүн	9,129,476,794.15	16,697,889,973.73
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	1,541,898,248.74	1,499,924,442.21
Биет бус хөрөнгө	30,803,476.07	28,138,513.92
Урт хугацаат хөрөнгө оруулалт	6,257,422,726.72	912,832,125.59
Хойшлогдсон татварын хөрөнгө	6,565,554.24	9,408,000.93
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	7,836,690,005.77	2,450,303,082.65
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	16,966,166,799.92	19,148,193,056.38
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
ӨР ТӨЛБӨР		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	535,094.32	4,478,841.33
Татварын өр	97,433,705.90	25,555,461.96
НДШ-ийн өглөг	-	14,092,790.89
Урьдчилж орсон орлого	10,794,974.45	4,313,008.26
Бусад богино хугацаат өр төлбөр	10,678,707,257.44	11,628,154,047.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	10,787,471,032.11	11,676,594,149.44
Нөөц/өр төлбөр/	100,000,000.00	100,000,000.00
Урт хугацаат өр төлбөрийн дүн	100,000,000.00	100,000,000.00
Өр төлбөрийн нийт дүн	10,887,471,032.11	11,776,594,149.44
Эздийн өмч		
Өмч : - төрийн	3,000,000,000.00	3,000,000,000.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	98,723,938.00	98,723,938.00
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	2,953,347,829.81	4,246,250,968.94
Эзэмшигчдийн өмчийн дүн	6,078,695,767.81	7,371,598,906.94
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	16,966,166,799.92	19,148,193,056.38

4.2.Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)	1,848,644,211.18	1,710,748,926.49
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	327,627,915.88	353,161,002.83
Нийт ашиг (алдагдал)	1,521,016,295.30	1,357,587,923.66
Хүүгийн орлого	1,784,951,560.71	1,625,121,459.51
Бусад орлого	84,629,949.05	36,391,511.67
Ерөнхий ба удирдлагын зардал	940,635,304.28	1,052,498,396.31
Санхүүгийн зардал		
Бусад зардал	17,909,017.08	133,546,746.41
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	100,988.28	89,342.68
Бусад ашиг (алдагдал)	-	2,842,446.69
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,432,154,471.98	1,835,987,541.49
Орлогын татварын зардал	187,286,775.07	169,472,422.82
Татварын дараах ашиг алдагдал	2,244,867,696.91	1,666,515,118.67
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	2,244,867,696.91	1,666,515,118.67
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Орлогын нийт дүн	2,244,867,696.91	1,666,515,118.67

4.3.Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2017 оны 12 сарын 31 - нээрх үлдэгдэл	3,000,000,000.00	98,723,938.00	-	824,903,551.48	3,923,627,489.48
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(16,025,495.45)	(16,025,495.45)
Залруулсан үлдэгдэл	3,000,000,000.00	98,723,938.00	-	808,878,056.03	3,907,601,994.03
Тайлант үеийн цэвэр ашиг				2,244,867,696.91	2,244,867,696.91
Бусад дэлгэрэнгүй орлого				2,902,496.87	2,902,496.87
Өмчид гарсан өөрчлөлт			26,624,000.00		26,624,000.00
Зарласан ногдол ашиг				(103,300,420.00)	(103,300,420.00)
2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	3,000,000,000.00	98,723,938.00	26,624,000.00	2,953,347,829.81	6,078,695,767.81
Залруулсан үлдэгдэл	3,000,000,000.00	98,723,938.00	26,624,000.00	2,953,347,829.81	6,078,695,767.81
Тайлант үеийн цэвэр ашиг				1,666,515,118.67	1,666,515,118.67
Зарласан ногдол ашиг				(373,611,979.54)	(373,611,979.54)
2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	3,000,000,000.00	98,723,938.00	26,624,000.00	4,246,250,968.94	7,371,598,906.94

4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	421,655,426,439.75	461,584,911,725.52
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,934,247,371.49	2,287,169,905.28
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	10,383,439.00	
Бусад орлого	419,710,795,629.26	459,297,741,820.24
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	(420,107,016,121.89)	(448,962,856,662.55)
Ажиллагсад төлсөн	(588,589,018.52)	(743,266,965.45)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(154,793,617.90)	(192,447,766.62)
Бараа материал худалдан авахад төлсөн	(14,080,725.00)	(32,046,549.82)
Ашиглалтын зардалд төлсөн	(261,941,422.52)	(14,868,135.55)
Түлш, шатахуун тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(4,704,397.00)	(10,117,541.00)
Хүүний төлбөрт төлсөн	(10,700.00)	-
Татварын байгууллагад төлсөн	(176,880,140.04)	(339,360,771.50)
Даатгалын төлбөрт төлсөн		(3,397,724.00)
Бусад мөнгөн зарлага	(418,906,016,100.91)	(447,627,351,208.61)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,548,410,317.86	12,622,055,062.97
Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	10,648,705,878.28	2,096,273,165.31
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	9,754,895,920.00	
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	16,733,090.98	
Хүлээн авсан хүүний орлого	877,076,867.30	2,096,273,165.31
Мөнгөн зарлагын дүн (-)	(10,549,043,206.72)	(65,596,500.00)
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(17,764,439.60)	(65,596,500.00)
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	(10,500,088,767.12)	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	(31,190,000.00)	
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	99,662,671.56	2,030,676,665.31
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	67,145.11	95,421.86
Валютын ханшийн олз	67,145.11	95,421.86
Мөнгөн зарлагын дүн (-)	(89,895,240.00)	(336,741,999.54)
Төлсөн ногдол ашиг	(89,895,240.00)	(336,730,154.54)
Валютын ханшийн алдагдал		(11,845.00)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(89,828,094.89)	(336,646,577.68)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,558,244,894.53	14,316,085,150.60
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	588,396,464.36	2,146,641,358.89
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,146,641,358.89	16,462,726,509.49

5. Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр	2019 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код
2020.03.12			САГ-2020/12/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:		Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК	Сая төгрөгөөр

No	Алдаа зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгуулл агаас гаргасан шийдэл	Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
A	3	4	5	8	9
1	2018 онд явуулсан худалдан авах ажиллагаанаас үүссэн маргаантай 24,995.8 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл байна. Энэ авлага тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, маргаантай байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "...үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах.." гэж заасанд нийцэхгүй байна.	25.0	Зөвлөмж өгсөн.	Гүйцэтгэх захирал	Ж.Байгалмаа
2	Тус компани нь Шилэн дансны тухай хуулийн 3.1.1-д хамаарах байтал 3.1.3 дахь заалтад хамааруулан эрх олгосноос зөвхөн худалдан авах ажиллагаа, том дүнтэй гэрээ хэлцлийн мэдээлэл оруулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 6 дугаар зүйлийг тус тус зөрчсөн байна.	-	Зөвлөмж өгсөн.	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Ж.Байгалмаа Л.Нарантуяа